



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 23 өдөр

Дугаар A/89

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Мягмарбилэг ХХК-ний “Баянбалбар” дэн буудлын 15/047, Эх Хийморь ХХК-ний “Хийморь” зочид буудлын 16/072, Зургаан талт ХХК-ний “Алим” зочид буудлын 13/160, Эс Pi Сервис ХХК-ний “Сансар” Дэн буудлын 16/058, Зол хайрхан ХХК-ний “Стелла” зочид буудлын 13/229, Жи Bi Эс импекс ХХК-ний “Хабу” зочид буудлын 16/117, Нью жаско ХХК-ний “Марс” дэн буудлын 16/117, Амма ХХК “Энжил” дэн буудлын 16/013 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг

Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсувд/-д үүрэг  
болгосугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 11. сарын 15.  
өдрийн дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт

1117139265  
УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.11.23

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрацийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Эх Хийморь ХХК	2594331	Хийморь	ХУД-ийн 2-р хороо Үйлдвэрийн гудамж 17-1
2	Зургаан талт ХХК	2610442	Алим	БЗД-ийн 14-р хороо ЭТӨЧ-Өөрийн байр
3	Зол халиун ХХК	2020114	Стелла	БГД-ийн 5-р хороо ЭТӨЧ-85
4	Жи Би Эс импекс ХХК	2767864	Хабу	БГД-ийн 1-р хороо Замчдын 48а

--ооОоо--

Нийслэлийн Аянал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 11. сарын 05  
өдрийн 11:55 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

117139265  
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.11.23

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мягмарбилэг ХХК	5129265	Баянбалбар	СХД-ийн 17-р хороо 1-р хорооллын гудамжны 59
2	Эс Пи Сервис ХХК	2572516	Сансар	БЗД-ийн 7-р хороо 15-р хорооллын Ахуйн үйлчилгээний төв
3	Иргэн Р.Олонбаатар	РЮ74022578	Намар	БЗД-ийн 4-р хороо Б.Доржийн гудамж 76
4	Нью Жаско ХХК	5168848	Марс	БГД-ийн 17-р хороо 66-1
5	Амма ХХК	2658151	Энжил	БГД-ийн 20-р хороо Толгойт Энжил үйлчилгээний төв

---ooOoo---